

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/11/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Аудитор М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТӨГРӨГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЧИМЭГБАЯР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 126

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв, соёлын төв, сургууль, цэцэрлэгийн хөрөнгө, өр төлбөрийн эхний үлдэгдэл шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 88.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0702000297

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,041,005.50	552,111.80
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,854,000.30	1,425,687.90
	Нийт хөрөнгийн дүн	4,895,005.80	1,977,799.70
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,876,310.20	1,970,034.70
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,876,310.20	1,970,034.70
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,001,626.70	1,536,591.20
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,406,805.20	882,266.50
	Үйл ажиллагааны үр дүн	594,821.50	654,324.70
	Үйл ажиллагааны бус үр дүн	30502.5	3,320,414.40
	Үйл ажиллагааны нийт үр дүн	564,319.00	-2,666,089.70
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,311,991.30	4,636,124.40
	Тайлант оны үр дүн	564,319.00	-2,666,089.70
	Эцсийн үлдэгдэл	4,876,310.30	1,970,034.70
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,277,771.10	1,125,246.40
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,962,802.50	809,643.70
	Үйл ажиллагааны ЦМГ	314,968.60	315,602.70
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-153,979.10	-359,248.50
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(90,000.00)	(71,000.00)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	70,989.50	(114,645.80)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	195,663.90	266,653.40
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	266,653.40	152,007.50
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,240,270.20	1,141,879.22
	Урсгал зардал	738,338.30	714,510.69
	Хөрөнгийн зардал	111,628.20	71,000.00
	Эргэж төлөгдөх зээл	390,303.70	356,368.53
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,240,270.20	1,141,879.22
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,067,764.30	1,032,333.58
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	172,505.90	71,188.26
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	38,357.38

Гурав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 1 төрийн сан, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Нэгж байгууллагуудын аудитаар 812.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж арилгасан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагуудын аудитаар нийт 364.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 19.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 344.1 сая төгрөгийн албан шаардлага, 1.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар нийт 65.0 сая төгрөгийн алдаа¹, зөрчлийг арилгасан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг 65.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг тус тус зөрчсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар нийт 2.8 сая төгрөгийн зөрчил² илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 1 заалт албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

- ✓ Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд хөрөнгийн орлого 0.4 сая төгрөгөөр, малын хөлийн албан татварын орлого 2.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Төгрөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 26 дугаар тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	3	65.02	1	10.00	2	55.02	3	65.02				
ЗДТГ	6	419.47	4	14.56	2	404.91	6	0.42				
ИТХ	-	-		-		-		-				
ОНХС	3	340.87	1	10.00	2	330.87	3	340.87				
БХНС	2	17.57	1	12.42	1	5.15		-				
СХС	2	35.06		-	2	35.06	2	35.06				
Дүн	16	877.97	7	46.97	9	831.00	14	441.36	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
ТТЗ		-										
ЗДТГ	13	268.59	4	7.41	8	259.98	1	1.20				
ИТХ	2	5.43	1	1.23	1	4.20						
ОНХС	5	75.86	1	1.31	4	74.54						
БХНС	1	4.50		-	1	4.50						
СХС	2	10.29	1	9.41	1	0.87						
Дүн	23	364.66	7	19.36	15	344.10	1	1.20	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	-							
ЗДТГ	1				1			
ИТХ	-							
ОНХС	-							
БХНС	-							
СХС	1						1	
Дүн	2	-	0	-	1	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ	1	2.84			1	2.84		
ЗДТГ	1						1	
ИТХ	1						1	
ОНХС	-							
БХНС	-							
СХС	-							
Дүн	3	2.84	0	-	1	2.84	2	-
Нийт дүн	5	2.84	0	-	2	2.84	3	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	5	3	2		2	1		
2	Тусгай сан	3		3					
2	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	9	4	5		3	1		